

13

ИХ СУРГУУЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ
ТОДОРХОЙЛОХ НЬ

Г.Билгээ

Дээд боловсролын байгууллагын гадаад, дотоод орчинд олон талт өөрчлөлт, шинэчлэл хийх боломжийг хууль эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийн хүрээнд баталгаажуулсан нь их сургуулийн үйл ажиллагааг бүрэн зохицуулах хэмжээнд хараахан хүрч чадаагүй хэдий ч өргөн хүрээтэй, практик шинэчлэлүүд хийгдэж эхлээд багагүй хугацаа өнгөрөөд байна. Эдгээр шинэчлэл нь хуучнаа шинэ рүү хөрвүүлэх, зохион байгуулалтын төдий арга хэмжээ бус зарим тохиолдолд үндсээр нь өөрчлөх шаардлагатай нэлээд төвөгтэй асуудлуудтай тулгарч түүнийг хэрхэн шийдвэрлэх нь байгууллагыг удирдах удирдлагын багийн чадавхи, бүтээлч хандлагаас ихээхэн шалтгаална.

Цаг үеэ олсон, сайтар зохион байгуулсан өөрчлөлт, шинэчлэл нь хөгжлийн гүүр болж чадах бөгөөд тухайн байгууллагын өвөрмөц онцлог, уламжлал, стратеги, хөгжилд хэрхэн хамгийн зөв арга замаар хүрэх арга, санхүүгийн чадавхи зэргээс хамааралтай байдаг.

Их сургуулийн үйл ажиллагаанд санхүүгийн менежментийн үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байгаагийн сацуу удирдах (үүнд стратегийн менежер төдийгүй тактикийн болон үйл ажиллагааны менежерүүд) ажилтанд тавигдах шаардлага ч өндөрсөж, энэ талын системтэй тогтолцоо үгүйлэгдэж байгаа нь харагдаж байна. Боловсролын удирдах ажилтныг мэргэшсэн удирдах ажилтан байдлаар бэлдэж байгаагүйгээс өнөөдөр боловсролыг үнэлэх үнэлэмж, боловсролын чанарт тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлж байгаа юм.

Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа нь бусад байгууллагын нэгэн адил бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн шинжтэй. Энэ нь хувь хүний амьдралын чанарт шууд нөлөөлөх, мэдлэгээ ашиглах чадвар (ухаан)-ыг хувь хүн ба нийгмийн хэрэгцээнд нийлүүлснээр улс орны хөгжлийг тодорхойлогч хүчин зүйлсэд бодитой хувь оруулах учиртай өвөрмөц шинжтэй, төрийн чиг үүрэгт хамаарах бүтээгдэхүүн юм.

“Төсвийн байгууллагын бүтээгдэхүүнийг тодорхойлох, бүтээгдэхүүний өртөг тооцох гарын авлага, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайлан гаргах журмыг үндэслэн доктор (Ph.d) Н.Тунгалаг, Л.Болдбаатар бид хамтран 2003 онд ШУТИС-ийн бүтээгдэхүүнийг тодорхойлон (Л.Болдбаатар “Дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүгийн менежментийн зарим асуудлууд” 2004 он, хууд. 87-94) практикт хэрэгжүүлэн нийтийн хүртээл болгосон нь боловсролын байгууллагын тухайд анхны ажил байсан бөгөөд цааш хөгжүүлэн судалсан бүтээл хараахан үгүй байна.

Хэдийгээр бүгдэд таарсан нийтлэг жор байх ёсгүй ч өнөөдөр манай оронд их сургуулийн бүтээгдэхүүнийг тодорхойлох талаар авч үзсэн судалгаа, цоо шинэ загварууд хэрэгтэй болоод байгаа нь:

1. Дээд боловсрол масс шинжтэй болж өрсөлдөөнийг бий болгосон нь стратегийн зорилгыг хэрэгжүүлэх
2. Худалдан авагч нь бүтээгдэхүүний үнийн тодорхой (суралцагч - сургалтын төлбөр, төр – тогтмол зардлыг төлөх ... зэрэг) хэсгийг буюу бүгдийг өөрөө төлдөг
3. Худалдан авагч нь байгууллагын зардлыг багасгах, үр ашигтай ажиллах хөшүүрэг бий болгох үүднээс бүтээгдэхүүний зардлыг тоон үзүүлэлтийн доод хязгаарыг баримтлан тогтоохыг эрмэлзэх
4. Бүтээгдэхүүнийг худалдан авагчийн шаардлагад нийцүүлэн чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлтийн дагуу нийлүүлэхээс гадна тохиролцсон /менежерийн үр дүнгийн гэрээгээр/ зардалд багтаан нийлүүлэх
5. Худалдан авагч, бүтээгдэхүүнд суурилсан төсвийн хязгаарт багтаан нийлүүлэх боломжгүй хэт өндөр чанартай бүтээгдэхүүн нийлүүлэхийг шаардах
6. Байгууллага, өөрийн нийлүүлэх бүтээгдэхүүний үнийн хязгаараас шалтгаалан бүтээгдэхүүний тоон үзүүлэлтийг дээд хязгаарт ойртуулан төсөв авахыг хүсэх
7. Хязгаарлагдмал нөөцийн хүрээнд (засгийн газраас ихээхэн зардал гаргахыг эсвэл иргэдийн нуруун дээрх ачааллыг нэмэгдүүлэх) нөөцийн хоорондын зохистой тэнцвэрийг олох
8. Худалдан авагч нь аливаа сонголтыг хийж, шийдвэр гаргахдаа нээлттэй, ил тод хийгдэх арга хэрэглүүрийг олох хэрэгцээ зэргээс шалтгаалж байна.

Их сургуулиас нийгэм, хэрэглэгчдээ үзүүлэх үйлчилгээ нь захиалагч болон нийлүүлэгчийн хувьд хариуцлагын тогтолцоог бий болгох харьцангуй өргөн боломжтой учир эцсийн бүтээгдэхүүний байдлаар багцлан шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн томъёолох үйл явцыг авч үзье.

1. Их сургуулийн бүтээгдэхүүн тодорхойлох

Сургуулийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчид болон тэднийг төлөөлөн захиалагч болж байгаа гадны (дээд шатны) байгууллага эцсийн бүтээгдэхүүнээр гэрээ хийх боловч дотоодын бүтээгдэхүүний өртөг нь эцсийн бүтээгдэхүүнд шингэж нийт төсвийг бүрдүүлэн байгууллагын хэтийн төлөвлөгөөнд дэлгэрэнгүй тусгах ёстой. Гэтэл байгууллагын дотоодын шинж чанартай боловч эцсийн бүтээгдэхүүний нийлүүлэлтэд нөлөөлж байдаг дотоод үйл ажиллагааны онцлогийг харгалзан ангилж шалгуур үзүүлэлтийг тогтоон бүтээгдэхүүн болгон томъёолох нь нэн түвэгтэй асуудал юм. Учир нь ийм үйл ажиллагааг хэрэглэгч төдийлөн анзаардаггүй, анзаарсан ч өөрийнх нь худалдан авах бүтээгдэхүүний өртөгт төдийлөн хамааралгүй хэмээн үздэгээс ач холбогдлыг нь бууруулахад хүргэдэг байна. Иймээс хэрэглэгч дотоодын үйл ажиллагаа (дотоодын бүтээгдэхүүн) ны өртгийг бууруулах шаардлагыг тавьдаг.

Сургалтын байгууллагын дотоодын бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн захиалсан эцсийн бүтээгдэхүүний чанар, үр дүнд нэн чухал ач холбогдолтой ажил үйлчилгээг багтаасан байдгийг анхаарах хэрэгтэй. Энэ талаар сургуулийн ажилтнууд сайн мэддэг боловч төсөв авах үндэслэлдээ бүрэн оруулж өгдөггүйгээс тайлагналд тусдаггүй, хариуцлагын тогтолцоог бүрхэгдүүлэхэд хүргэдэг байна. Энэ нь байгууллагын дотоодын үйл ажиллагааг гүйцэтгэдэг ажилтнуудын идэвхи, хариуцлагыг сулруулах, төсвийн зарцуулалтын үр өгөөжийг бууруулахад нөлөөлнө.

Сургуулийн бүхий л үйл ажиллагааг оновчтой томъёолон бүтээгдэхүүн болгон багцлах нь хариуцлагын тогтолцоог нэгж хэсэг бүр цаашдаа ажилтан бүртэй байгуулах гэрээний үндэслэл болгох бөгөөд эцсийн бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж байгаа явдал юм.

Удирдлага зохион байгуулалтын ажил нь нэг талаас байгууллагын дотоод дахь бүхий л ажилтай уялдах учир бусад бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлттэй давхардуулахгүй, удирдлагын дотоод мэдээлэлд хэрэгцээтэй боловч эцсийн бүтээгдэхүүнд төдийлөн ач холбогдолгүй үзүүлэлтийг сонгохгүй байх хэрэгтэй. Энэхүү өргөн хүрээтэй асуудлуудаас тухайн жилд хийх ажлыг багцлан бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтийг хангах байдлаар томъёолон гаргаснаар захиргааны зүгээс хэрэгжүүлж байгаа ажил нийтэд ил тод, хариуцлагын тогтолцоог бүрдүүлж чадахуйц байх шаарлагатай.

Харин сургуулийн хэмжээний бүтээгдэхүүн болгон томъёолж болохооргүй ажил үйлчилгээг тухайн ажилтантай байгуулах үр дүнгийн гэрээнд оруулан тооцож болно. Ингэснээр ажлын байр бүр тодорхой үүрэг, хариуцлагатай байх болно.

Сургуулийн нэгж хэсгүүдийн ажил үйлчилгээний нэг хэсэг нь эцсийн бүтээгдэхүүн болохоор байхад, нөгөө хэсэг нь дотоодын бүтээгдэхүүн, зарим нь дангаараа бүтээгдэхүүн болж чадахгүй завсрын шинж чанартай ч байж болно.

Бүрэлдэхүүн сургуулийн захирал гадагш болон дотоодод нийлүүлэх бүтээгдэхүүнээр ректортой үр дүнгийн гэрээ байгуулна.

Их сургуулийн ректор (ерөнхий менежер) салбарынхаа сайд (төсвийн ерөнхий захирагчтай) гадагш нийлүүлэх бүтээгдэхүүн (Анги 1, Анги 2)- ээр гэрээ байгуулна.

1. Дотоодын нэгж хэсгийн бүтээгдэхүүн тодорхойлолт

Байгууллагын удирдлагын бүтэц, үйл ажиллагааны хүрээнээс хамааран дотоодын нэгж хэсэг, тэдгээрийн нийлүүлэх бүтээгдэхүүнийг тодорхойлно.

Их сургуулийн дотоодын нэгжийг дараах байдлаар авч үзье.

- төв аппарат - 5 газар, төвүүд
- бүрэлдэхүүн сургууль тус бүр :
 - профессорын баг тус бүр
 - судалгааны төв тус бүр
 - санхүү, үйлчилгээний хэсэг
 - сургалтын алба
 - оюутны
 - номын сан г.м

Бүтээгдэхүүнд суурилсан удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхийн тулд байгууллагын хүрэх үр дүнг төсөвтэй нь уялдуулан төлөвлөх, үйл явцад нь хяналт тавих, тайлагнах боломжийг үйл ажиллагааны нэгж, хэсэг бүрт бүрдүүлэх шаардлагатай. Үүнд:

- а) Байгууллагын бүтцийн схемийг зураглах
- б) Нэгж хэсэг бүрийн үйл ажиллагааны хүрээг тодорхойлох
- в) Ажилтан бүрийн хийж гүйцэтгэх ажлыг тодорхойлсон байх (ажлын байрны тодорхойлолт)
- д) Албан тушаалын жагсаалтыг гаргах
 - ижил төрлийн ажил гүйцэтгэдэг байдлаар нь
 - ялгаатай (зөвхөн тухайн ажилтан л дангаар гүйцэтгэх)

Эдгээрийг хийж гүйцэтгэснээр ажил үйлчилгээг бүтээгдэхүүн болгон тооцох дараахь шалгуурт нийцүүлэх үзүүлэлтийг сонгоно.

- ажил үйлчилгээний (тоо, давтамж)
- үргэлжлэх хугацаа (сар, улирал, санхүүгийн жил)
- чанар (стандарт, дүрэм, журам, гэрээнд зааснаар)
- төсөв (эх үүсвэр, мөнгө - мян.төг)
- хүрэх үр дүн

Тухайн нэгж хэсгийн үйл ажиллагааны хүрээг тодорхойлсноор тэдгээрийн бусад нэгжтэй хамтран гүйцэтгэх ажлын уялдаа холбооны хамаарлын дараалал тогтож, ажлын байрны ашиглалтыг сайжруулах (ажилтны ур чадвар), ачаалалыг жигдрүүлэх, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, үр дүнг үнэлэх боломж бүрдэнэ.

Нэгж хэсгүүдийн гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээ нь ямар бүтээгдхүүнийг нийлүүлэхэд ямар хувь хэмжээтэй оролцож байна вэ? гэдгийг боломжийн хэмжээнд хянах. Ингэснээр тухайн үйл ажиллагаа нь дотоодын бүтээгдэхүүн үү, эцсийн бүтээгдэхүүн үү гэдгийг томъёолно.

Нэгжийн үйл ажиллагааны зарим ажил нь эцсийн бүтээгдэхүүн байж болно.

Гэтэл тухайн нэгжийн хувьд эцсийн бүтээгдэхүүн боловч байгууллагын хэмжээнд авч үзвэл эцсийн бүтээгдэхүүний үр дүнд нөлөөлж байдаг дотоодын бүтээгдэхүүн болох нь бас бий. Жишээ нь: Профессорын багийн багш нарын бичиж хэвлүүлсэн сурах бичиг тухайн багийн эцсийн бүтээгдэхүүн боловч сургуулийн хувьд баклавар, магистрийн сургалтын хөтөлбөрт нөлөөлөх дотоодын бүтээгдэхүүн болно.

Нэгж хэсгүүдийн үйл ажиллагааны хүрээг хэд хэдэн бүтээгдэхүүн болгон авч үзэхдээ бүтээгдэхүүн бүрийн шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулна. Бүтээгдэхүүн бүрт тохирсон томъёололыг өгүүлбэрээр илэрхийлнэ. Энэ нь уг бүтээгдэхүүний талаарх ойлголт аливаа хүн (байгууллага) –д адил байхаар бичигдсэн байна.

Шинж чанараараа ижил төстэй бүтээгдэхүүнийг нэгтгэн нэг анги болгоно. Хичнээн анги, хичнээн бүтээгдэхүүн байх нь үйл ажиллагааны хүрээнээс хамаарах боловч хэт олон болгож жижиглэх нь дэндүү их хугацаа, зардал шаардах, төсвийн төлөвлөгөө зохиох, тайлагнах, хяналт тавих боломжийг бууруулахад хүргэж болох тул байгууллагын үйл ажиллагаанд эрс өөрчлөлт ороогүй тохиолдолд харьцангуй тогтвортой байж, шаардлагатай үед ангийг төдийлөн хөндөхгүйгээр зөвхөн аль нэг бүтээгдэхүүнд хамааруулж болохуйцаар өөрчлөх боломжтой байх.

Нэгж бүрийн үйл ажиллагааны хүрээг тодорхойлж бүтээгдэхүүн болгон багцалснаар үр дүнгээр нь санхүүжүүлэх төсөвтэй байх үндэслэл болно. Цаашдаа ажилтан бүртэй гэрээ байгуулж дүгнэх боломж ч бүрдэнэ. Тухайлбал; профессор багийнхаа багш, эрдэм шинжилгээний ажилтан, хичээлийн туслах ажилтан нартай үр дүнгийн гэрээ байгуулах, бүтээгдэхүүнээ тодорхойлох асуудлаар сургуулийнхаа захиралтай тохиролцоонд хүрснээр жилийн төсөв авах үндэслэл болно.

3 Бүрэлдэхүүн сургуулийн бүтээгдэхүүн тодорхойлолт

Сургууль дотоодын нэгж хэсгүүдийн бүтээгдэхүүнийг ижил чиглэлээр нь

- Гадагш нийлүүлэх
- Сургуулийн дотоодод нийлүүлэх гэж багцлана.

Сургууль нь төрийн үйлчилгээний байгууллагын хувьд бусад байгууллага, иргэдийн хэрэгцээг хангах чиглэлийн үйл ажиллагаа явуулж байна.

Иймд гадагш нийлүүлэх бүтээгдэхүүнийг дараахь байдлаар томъёолов.

Анги 1. Сургалтын хөтөлбөр Анги 2. Эрдэм судлалын ажил

Бүтээгдэхүүн

Бүтээгдэхүүн

- | | |
|--|--|
| 1.1 Баклаварын сургалт | 2.1 Эрдэм шинжилгээний бүтээл |
| 1.2 Магистрийн сургалт | 2.2 Эрдэм шинжилгээний төслийн ажил |
| 1.3 Докторын сургалт | 2.3 Захиалгат ажил, технологи дамжуулалт |
| 1.4 Модуль сургалт | |
| 1.5 Лицейн, мэргэжлийн анхан шатны сургалт | |

Олон мэргэжлийн хөтөлбөрийн чиглэлээр сургалт явуулж байгаа боловч боловсролын түвшин, хэлбэрийн ялгаатай байдлыг харгалзан Сургалтын хөтөлбөр гэсэн ангийг 5 бүтээгдэхүүн болгон багцална. Энэ ангийн

1.1 баклаварын, 1.2 магистрын, 1.3 докторын сургалт гэсэн бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтийн

тоо хэмжээ: мэргэжлийн хөтөлбөрийн тоо, оюутны тооны жигнэсэн дундаж (элсэлт, II- төгсөх курсын суралцагчийн өмнөх жилийн тоог дэвшүүлж тооцох), жилд дунджаар сонгон суралцах кредит (баклавар 120к/4 жил, магистр (40-60к)/(1.5-2 жил), доктор (60-90к)/3 жил)-ийн дүнгээр

чанар: кредитийн үнэлгээний голч дүнгийн хүрэх түвшингээр

хугацаа: санхүүгийн жилийн төсөв, тайлагналтай уялдуулан тухайн хичээлийн жилийн 2007 оны (I-VI сар) хавар, 2008 оны (IX-XII сар) намрын улирлын үргэлжлэх хугацаа

өртөг: санхүүгийн тайлангийн зардлаас тухайн бүтээгдэхүүнд хуваарилагдан ноогдох зардал (мянган төгрөгөөр)

хүрэх үр дүн: сургалтын хөтөлбөрийн стандартад нийцсэн мэдлэг, дадлыг эзэмшүүлснээр суралцаж байгаа оюутнуудаас дэвшүүлэн суралцах, төгсөх оюутны тоо, төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин гэх мэт

Бүтээгдэхүүн 1.3 Докторын сургалтын тухайн сургууль дээр явагдсан сургалтын ажлын төгсөх хүртэлх үр дүн бүрэлдэхүүн сургуульд хамаарах боловч өртөг, горилогчийг хамгаалуулах ажлын үр дүн нь эрдэм шинжилгээ, доктрантын газарт нэгдсэн байдлаар тооцогдоно.

Бүтээгдэхүүн 1.4 Модуль сургалт (мэргэжил дээшлүүлэх, захиалгат, түр, зайны сургалт)-ын сертификат олгох хөтөлбөрийн тоо, удаа, тухайн хөтөлбөрийн бүрээр үргэлжлэх хугацаа, өртгийг тооцно.

Бүтээгдэхүүн 1.5 Лицейн сургалтад

- мэргэжлийн анхан шатны сургалт
 - ерөнхий боловсролын X-XII анги
- хөтөлбөр тус бүрээр тухайн жилд суралцах оюутны тоо, сурлагын чанарын хүрэх түвшин, дэвшин суралцах болон боловсролын гэрчилгээ олгох сурагчийн тоог шалгуур үзүүлэлтээр сонгох

Эрдэм судлалын ажлыг 3 бүтээгдэхүүн болгон багцлав.

Бүтээгдэхүүн 2.1 Эрдэм шинжилгээний бүтээлийн шалгуур

тоо хэмжээ: бүтээлийн хэвлэлийн хуудсны тоогоор

чанар: эрдэм шинжилгээний бүтээлд тооцох шаардлагыг хангасан хэвлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээлийн тоо

хугацаа: санхүүгийн жилийн хугацаанд

хүрэх үр дүн: тухайн жилд хэвлүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлийн тоог үндсэн багшийн тоонд харьцуулсан түвшингээр, патент, практикт нэвтрүүлсэн.

өртөг: эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн, бүтээл шалгаруулах, хэвлүүлэхтэй холбогдож сургуулийн үндсэн үйл ажиллагааны эх үүсвэрээр санхүүжих төсвийн дүнгээр

Бүтээгдэхүүн 2.2 Эрдэм шинжилгээний төслийн ажил

ШУТехнологийн сангийн төслийн, Улсын захиалга болон бусад гадаад дотоодын төслөөр санхүүжих ажлын тоогоор чанар, хугацаа, өртөг, үр дүнг тус тус тооцно.

Бүтээгдэхүүн 2.3 Захиалгат ажил, технологи дамжуулах

Байгууллагын захиалгаар гүйцэтгэх ажил, оруулж ирсэн болон дамжуулсан технологи бүрт хамаарах ажлыг шалгуур үзүүлэлтээр тооцно.

Гадагш нийлүүлэх эцсийн бүтээгдэхүүнд нөлөөлөх дотоодын бүтээгдэхүүн болох чиглэлийн үйл ажиллагааг багцлан 3,4, 5-р ангид хамааруулав.

Анги 3. Сургалтын арга зүйн үйлчилгээ

Сургалтын хөтөлбөрт хамаарах бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтэд ордоггүй боловч их сургуулийн үндсэн бүтээгдэхүүний үр дүнд зайлшгүй нөлөөлж эцсийн бүтээгдэхүүний өртөгт хуваарилагдах өртөг бүхий ажил үйлчилгээний төрөл юм.

Анги 4. Захиргаа, санхүү аж ахуйн үйлчилгээ

Энэ ангид удирдлагын шинж чанартай болон гадаад хамтын ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэл, хангамж үйлчилгээний ажлыг багцлан 4 бүтээгдэхүүнд томьёолов. Үүнээс:

Бүтээгдэхүүн 4.4 Хангамжийн үйлчилгээ

Байр ашиглалттай холбоотой засвар тохижилтын ажил, харуул хамгаалалт, цэвэрлэгээ, тоног төхөөрөмж, материал хангамж, тээврийн үйлчилгээ, ус, дулаан, цахилгаанаар хангах зэргийг хамааруулна.

Анги 5 Оюутны үйлчилгээ

Оюутанд зөвлөх, зуучлах, урлаг спортын арга хэмжээ, оюутны байр, эмнэлэг, цайны газрын үйлчилгээ. Эдгээрээс зөвхөн оюутны байрын үйлчилгээ, цайны газрын үйлчилгээний санхүүгийн эх үүсвэр нь орлогоороо тооцогдох бөгөөд гадагш нийлүүлэх байж болно.

Бүтээгдэхүүн 5.1 Оюутанд зөвлөх үйлчилгээ

Оюутанд хичээл сонгоход нь туслах, хичээлийн хуваарийг зохицуулах, шаардлагатай мэдээллээр хангах, оюутны хөдөлгөөнтэй холбогдох тушаал бэлтгэх, бүртгэл судалгааг хөтлөх, сургалтын төлбөрийн картыг хөтлөх зэрэг сургалтын албаны үйл ажиллагаа байна.

Бүтээгдэхүүн 5.2 Оюутанд зуучлах үйлчилгээ

Оюутныг ивээн тэтгэх, хөнгөлөлт тусламж үзүүлэх төрөл бүрийн санд хамруулах ажлыг зохион байгуулахтай холбоотой ажил үйлчилгээ (Сургалтын төрийн сангийн зээл, ТАХХ зардал, буцалтгүй тусламж г.м)

Мөн хичээлийн хажуугаар ажиллаж болох боломжоор хангах зэрэг болно.

Дүгнэлт

Судалгаа, туршилтын ажлын явцад дараахь дүгнэлтүүд гарч байна. Үүнд:

1. Их сургуулийн бүтээгдэхүүнийг тодорхойлох, бүтээгдэхүүний ангийг тогтоох, тоо, чанар, хугацаа, өртөг, үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагад нийцүүлэх нь нэлээд төвөгтэй асуудал бөгөөд тухайн байгууллагын гадаад, дотоод орчин ялангуяа удирдлагын багийн менежментийн түвшингээс хамаарна. Засгийн газар, их сургуулийн сургалтын бүтээгдэхүүнээр худалдан авалт хийхгүй байгаа нь ТБУСТХ-ийг хэрэгжүүлэх хүрээнд их сургуулийн удирдлага (ректор)-ыг албан тушаалд ажиллуулах нөхцлийг нэг, "Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ"-нд тусгагдах үзүүлэлт төдий харагдахад хүргэж байгаа юм. Иймд их сургуулийн бүтээгдэхүүнийг төсвийн санхүүжилттэй /тодорхой урамшуулалтай / холбох нь чухал.
2. Бүтээгдэхүүний тооны өөрчлөлтийг чанарын өөрчлөлт болгож чадсанаар шударгаар өрсөлдөх орчныг бүрдүүлэх, төр, бизнесийн байгууллагууд зах зээлийн эдийн засгийн харилцааны шаардлагад тохирсон чанартай бүтээгдэхүүнийг өндөр үнээр захиалан авбал, сургалтын төлбөрийг, эсвэл оюутны тоог нэмэх замаар их сургууль төсвөө бүрдүүлж байгаа одоогийн байдлыг өөрчилж, их сургуулийн санхүүжилтийн эх үүсвэрт төрийн хариуцах хувийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ мэдлэг, чадвартай оюутан залуучуудын нийгмийн байдлыг үл харгалзан төрөөс дэмжих хэлбэр болно. Үүний тулд

бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтүүдийн стандартыг нарийвчлан тогтоох шаардлагатай.

3. Бүтээгдэхүүнийг тодорхойлсноор бүтээгдэхүүний нийлүүлэлтийн талаар мэдээлэлтэй болох, хянах /магадлан итгэмжлэх/, нөөцийг хуваарилах, төлөвлөх, бүтээгдэхүүний чанар, өртгийг тодорхойлох, оновчтой шийдвэр гаргах боломжтой болно.

4. Бүртгэлийн аккруэл суурь болон сургалтын кредит системийг бүрэн нэвтрүүлж, программ хангамжийн асуудлыг шийдвэрлэснээр илүү уян хатан байх боломжтой, бүтээгдэхүүнд үндэслэсэн удирдлагын хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлнэ.

5. Их сургуулийн бүтээгдэхүүнийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнг нь практикт хэрэгжүүлснээр бусад их, дээд сургуулиудад ач холбогдолтой байгаад зогсохгүй дээд боловсролын санхүүгийн удирдлагын салшгүй хэсэг болгон авч үзэх нь зүйтэй.

Бүтээгдэхүүнийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнг нь практикт хэрэгжүүлснээр бусад их, дээд сургуулиудад ач холбогдолтой байгаад зогсохгүй дээд боловсролын санхүүгийн удирдлагын салшгүй хэсэг болгон авч үзэх нь зүйтэй.

Бүтээгдэхүүнийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнг нь практикт хэрэгжүүлснээр бусад их, дээд сургуулиудад ач холбогдолтой байгаад зогсохгүй дээд боловсролын санхүүгийн удирдлагын салшгүй хэсэг болгон авч үзэх нь зүйтэй.

Бүтээгдэхүүнийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнг нь практикт хэрэгжүүлснээр бусад их, дээд сургуулиудад ач холбогдолтой байгаад зогсохгүй дээд боловсролын санхүүгийн удирдлагын салшгүй хэсэг болгон авч үзэх нь зүйтэй.

Бүтээгдэхүүнийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнг нь практикт хэрэгжүүлснээр бусад их, дээд сургуулиудад ач холбогдолтой байгаад зогсохгүй дээд боловсролын санхүүгийн удирдлагын салшгүй хэсэг болгон авч үзэх нь зүйтэй.

Бүтээгдэхүүнийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнг нь практикт хэрэгжүүлснээр бусад их, дээд сургуулиудад ач холбогдолтой байгаад зогсохгүй дээд боловсролын санхүүгийн удирдлагын салшгүй хэсэг болгон авч үзэх нь зүйтэй.

Бүтээгдэхүүнийг тодорхойлох судалгаа хийж, үр дүнг нь практикт хэрэгжүүлснээр бусад их, дээд сургуулиудад ач холбогдолтой байгаад зогсохгүй дээд боловсролын санхүүгийн удирдлагын салшгүй хэсэг болгон авч үзэх нь зүйтэй.

Ашигласан ном зүй

1. Дээд боловсролын тухай Монгол улсын хууль, УБ,1995, (шинэчилсэн найруулга 2002)
2. “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль” УБ, 2002
3. “Улсын салбарын удирдлага санхүүжилтийн шинэчлэл” УБ,2003
4. Д.Бадарч, Д.Энхболд, Г.Батхүрэл нар “Кредит систем” УБ, 2000
5. Н.Тунгалаг, З. Л.Болдбаатар, Г.Билгээ “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг ШУТИС дээр зохион байгуулах” сэдэвт төслийн ажлын тайлан, УБ, 2003
6. UNESCO Instiute for Statistics (2007)Education counts:Benchmarking Progress in 19 WEI countries. World Education Indicators 2007, Montreal (www.uis.unesco.org/publications/wei 2007)